

**МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН УЛААНБААТАР
ТӨМӨР ЗАМЫН АЧАА ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ СИСТЕМ (АТҮЦС)
ПРОГРАМААР БИЧИГ БАРИМТ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР СОЛИЛЦОХ ГЭРЭЭ**

Улаанбаатар хот

20__оны __сарын__

Нэг талаас Нэг талаас "Улаанбаатар Төмөр Зам "ХНН- ийг төлөөлж тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан орлогч дарга /цаашид " УБТЗ " гэх/, нөгөө талаас Монгол улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа "Үйлчлүүлэгч" гэх хуулийн этгээд болох-ийг төлөөлж /цаашид хамтаа "Талууд" гэх/ бид Монгол улсын иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр /ОАХХ/, Ачааны вагон эдэлгээний дүрэм /АВЭД/, Нэгдсэн нэвтрэх тариф /ННТ/, УБТЗ-д мөрдөгдөж байгаа дүрэм, журам, заавар, тарифын мөрдлөгийг удирдлага болгон дараах нөхцөл бүхий энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1. УБТЗ-аар ачаа болон хоосон вагон тээвэрлэх ажиллагааг зохион байгуулах үед тоон гарын үсэг ашиглан тээврийн болон өөр бусад бичиг баримт үйлдэхэд Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем (АТҮЦС) програм ашиглан бичиг баримтуудыг цахимаар солилцох дүрэм(цаашид – Дүрэм гэх)-д заасан журам болон ачаа тээврийн захиалга өгөх, тээвэрлэлтийн бичиг баримтууд, өөрийн хөдлөх бүрэлдэхүүний тээврийн бичиг баримт үйлдэх, цахим падаанд ачаа тээвэрлүүлэх болон ачааны аюулгүй байдлыг хангах тухай мэдээллийг оруулах, тээврийн гэрээ өөрчлөх (ачааны хаяг солих) захиалга өгөх, түүнтэй холбоотой тайлан мэдээ авах зэргийг тоон гарын үсэг зурсан цахим бичиг баримтуудыг солилцож байхаар тохиролцов.

Энэ заалтанд заасан Дүрэм болон технологиудыг УБТЗ-ын www.ubtz.mn сайтын "Ачаа тээвэр" гэсэн хэсэгт байрлуулсан болно.

2. УБТЗ-ын Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем (АТҮЦС) програмаар цахим бичиг баримтын солилцоог мэдээллийн хамгийн өндөр нууцлалт бүхий хамгаалалтын хэрэгсэл болон баталгаажуулалтын төвөөс талуудад олгосон тоон гарын үсгийн түлхүүрийн гэрчилгээг ашиглан явуулна. Гэдгийг талууд баталгаажуулна. Баталгаажуулалтыг УБТЗ-аас заавал баталгаажуулна.
3. Талууд харилцан ажиллах үедээ тоон гарын үсэг зурсан дараах цахим бичиг баримтуудыг солилцон (зайлшгүй шаардлагатай байгааг дурьдах)
 - Орон нутгийн ачаа тээвэрлэх хүсэлт
 - Экспортийн ачаа ачуулах хүсэлт
 - Дамжин өнгөрөх ачаа тээвэрлүүлэх хүсэлт
 - Чингэлэг тээвэртэй холбоотой хүсэлт
 - Аюултай ачаатай холбоотой хүсэлт
 - Хэтрүү овортой, хүнд жинтэй, урт ачаа тээвэрлэх хүсэлт
 - Түргэн гэмтэх, муудах ачаа тээвэрлэх хүсэлт
 - Хаяг солих хүсэлт
 - Төлөвлөгөө гэрээний дагуу ачаа тээвэрлэх хүсэлт
 - Нэмэлт захиалгатай холбоотой хүсэлт
 - ТЗ-ын ААН ачаа тээвэрлүүлэх хүсэлт
 - Төлбөр тооцоотой холбоотой хүсэлт
 - Ачаа тээвэрлүүлэх шаардлагатай тээврийн бичиг баримт
 - Өөрийн хөдлөх бүрэлдэхүүн тээвэрлэхтэй холбоотой хүсэлт
 - Тээврийн бичиг баримт
 - Санамж
 - Элдэв хураамж

- Ачилтын мэдээ
 - Ирэлтийн мэдээ
 - Төлбөр тооцооны тайлан
4. Үйлчлүүлэгчийг холбох ажиллагааг захиалагчийн гаргасан хүсэлтийг үндэслэн УБТЗ-ын ХНН-г Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем (АТҮЦС) програмд нэвтрэх зөвшөөрөл олгох заавар схемийг дагуу явагдана.

Хоёр. УБТЗ-ын хүлээх үүрэг

1. Үйлчлүүлэгчийн хүсэлт, гэрээний дагуу тогтоосон хугацаанд тухайн байгууллагын хариуцлагатай ажилтанд АТҮЦС-д нэвтрэх зөвшөөрөл олгох.
2. Үйлчлүүлэгчийн бичиг баримтын нууцлалыг хамгаалах, нэвтрэх эрхийн мэдээллийг гуравдагч этгээдүүд хууль бусаар дамжуулахгүй байх.
3. Үйлчлүүлэгчийн нууцад хамаарах мэдээллийг задруулсан, мөн түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлын шаардлага зөрчсөн өөр бусад тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлөх.
4. УБТЗ-ын Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем (АТҮЦС) програмд холбогддог сервер, вирусын эсрэг хамгаалалт болон мэдээллийн аюулгүй байдал, стандартуудын дагуу мэдээлэлд зөвшөөрөлгүй орохоос хамгаалах.

Гурав. Үйлчлүүлэгчийн хүлээх үүрэг:

1. УБТЗ-ын ачаа тээвэрлэлт болон бичиг баримтын нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хамгаалах.
2. Зөвхөн УБТЗ-ын албан өгсөн зөвшөөрлийн дагуу цахимаар хүлээн авсан мэдээллээ гуравдагч этгээдэд дамжуулах.
3. Үйлчлүүлэгчийн өөрийн гаргасан эсвэл түүний олж мэдсэн нууцлалыг алдагдуулсан үйлдэл эсвэл нууцлал алдагдах аюул учирсан, үйлчлүүлэгчийн нэвтрэх эрх олж авсан мэдээллийг гуравдагч этгээдүүд хууль бусаар олж авсан эсвэл хууль бусаар ашигласан тухай баримтыг нэн даргуй УБТЗ-д мэдэгдэх.
4. Үйлчлүүлэгч нь УБТЗ-ын нууцад хамаарах мэдээллийг задруулсан, мөн түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлын шаардлага зөрчсөн өөр бусад тохиолдолд УБТЗ-д учирсан хохирлыг нөхөн төлөх.
5. УБТЗ-ын Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем (АТҮЦС) програмд холбогддог сервер, вирусын эсрэг хамгаалалт болон УБТЗ-ын мэдээллийн аюулгүй байдлын бодлого болон стандартуудын дагуу мэдээлэлд зөвшөөрөлгүй орохоос хамгаалах хамгаалалтаар хангах.

Дөрөв. Бусад

1. УБТЗ-ын ачаа тээврийн үйлчилгээний цахим систем (АТҮЦС) програмаар цахим бичиг баримт солилцож эхлэх огноог талууд харилцан тохиролцож, энэүү гэрээний дагуу тоон гарын үсэг ашиглан солилцоход бэлэн болсныг баталгаажуулан хамтарсан протоколд зааж өгнө.
2. Энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар Үйлчлүүлэгч нь дүрэм болон технологиудад заасан УБТЗ-ын ачаа тээврийн үйлчилгээний цахим систем (АТҮЦС) програмаар цахим бичиг баримт солилцох журамтай танилцаж, зөвшөөрсөн гэдгээ баталгаажуулна.
3. Энэхүү гэрээг 20__ оны __ өдөр хүчин төгөлдөр болж, 20__ оны __ сарын __ өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.
4. Гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас 15 хоногийн өмнө аль нэг тал нь Гэрээг цуцлах тухай мэдэгдээгүй тохиолдолд энэхүү Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа дараагийн хуанлийн жил бүр сунгагдаж болно.

Гэрээ байгуулсан:

УБТЗ ХНН-ийг төлөөлж :
Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан
орлогч дарга

Үйлчлүүлэгчийн төлөөлж:

.....

.....

Талуудын хаяг

УБТЗ ХНН

Үйлчлүүлэгч:

УБ хот, УБТЗ-ын Удирдах Газар,
Шуудангийн хаяг: Р.О.ВОХ-376
Харилцах утас:
244403, 242300, 242307